



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/17

Хажуу шинэ ус

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх,
оролцоог хангах орон тооны бус дэд
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хамгаалах тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4, 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамгаалах тухай хууль, төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дэмжих, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах чиг үүрэг бүхий хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх оролцоог хангах орон тооны бус дэд зөвлөлийг хавсралтаар баталсугай.

2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний соёл, боловсрол, эрүүл мэнд, биеийн тамир, хөдөлмөр эрхлэлт, хувь хүнийг хөгжүүлэх, эрх чөлөөг хүндэтгэх талаар олон талт үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэнд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.АРИУНАА